ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН
“БОР-ӨНДӨР” БАГА СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2024 оны 04 сарын 22 өдөр Дугаар б/29 Бор-Өндөр

Зарим багш, ажилтанд нэмэгдэл хөлс
олгох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйлийн 145.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1, 8 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бага ангийн багш М.Баттуяа, С.Мөнхцэцэг, Б.Ганчимэг, З.Нямдулам, Д.Наранцэцэг нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын дүгнэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд үйлчилгээ үзүүлж байгаа төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн нөхцлийн нэмэгдэл хөлсийг тус бүр үндсэн цалингийн 20 хувиар, эмч Д.Эрдэнэчимэгт төрийн албанд ажилласан жилийг харгалзан үзэж төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл хөлсийг үндсэн цалингийн 25 хувиар тус тус олгосугай.

2. Дээрх багш, ажилтаны нэмэгдэл хөлсийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сар бүр бодож олгохыг нягтлан бодогч (Б.Анхчимэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ч.АМАРЖАРГАЛ

1823060009 4206789

D:\Zulaa\Tushaal.docx